



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 4/301

Мандалговь


Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа  
зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 3.1, 10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

- Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоолын дагуу Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 2 байршилд нийт 372м<sup>2</sup> (0,0372 га) газарт амины орон сууц болон худалдаа үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулж, дуудлага худалдаа явуулах хугацааг хавсралтад заасны дагуу нийтэд зарлан мэдэгдэж, хэрэгжүүлэх ажлыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822111023